



“VISUAL LAW” БУЮУ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЯЛБАРШУУЛАН ДҮРСЛЭХ АРГЫГ ХЭРЭГЛЭЭНД НЭВТРҮҮЛЭХ НБ

INTRODUCTION TO THE APPLICATION OF VISUAL LAW AS A METHOD FOR SIMPLIFYING LEGAL PROVISIONS

Амарсайханы Отгонсүх¹

Shihutug University, E-mail: otgonsukh@shihutug.edu.mn, <https://orcid.org/0009-0009-2400-6048>

ӨГҮҮЛЛИЙН ТУХАЙ

ХУРААНГУЙ

Түлхүүр үгс:

“Зурган хууль”, хууль зүйн мэдлэгийн хүртээмж, хялбаршуулалт, хүн төвтэй хандлага, зурган сэтгэлгээ

Keywords:

Visual law, access to legal knowledge, simplification, human-centric approach, visual thinking

Нийтлэлийн түүх:

Хүлээн авсан: 2025, 10 сар
Шинэчилсэн: 2025, 10 сар
Зөвшөөрсөн: 2025, 10 сар

Article history:

Received Oct, 2025
Revised Oct, 2025
Accepted Oct, 2025

Өдрөөс өдөрт шинэ агуулгаар баяжин өргөжиж буй нийгмийн харилцааг зохицуулах хэрэгцээ шаардлагаас үүдэн хууль тогтоомжийн тоо хэмжээ тасралтгүй өсөж байна. Нөгөө талаас эрх зүйт төрийн тогтолцоонд иргэд эрх, эрх чөлөөгөө эдлэх, хамгаалах, зөрчигдсөн тохиолдолд сэргээлгэх, төрийн үйлчилгээг авах болон бусад хэлбэрээр нийгмийн харилцаанд идэвхтэй, бие даан оролцоход тэдний хууль, эрх зүйн мэдлэг хангалтгүй байна. Энэ асуудлыг шийдвэрлэх хүрээнд олон улсад “Visual law” гэх нэршилээр хууль тогтоомжийн зохицуулалт, процессыг үгээр бус зураг, дүрслэлийн бусад арга хэрэгслээр хялбаршуулан илэрхийлэх чиг хандлага хөгжиж байна.

Энэхүү өгүүлээр Монгол Улсын хувьд харьцангуй шинэ ойлголт байж болох “Зурган хууль”-ийн сэтгэлгээ, хандлагын онцлог, ач холбогдол, анхаарах асуудлыг хөндөн танилцуулах, судлаач, сонирхогч талуудын анхааралд өртүүлэхийг зорьсон болно. Мөн өгүүллийн төгсгөлд “Зурган хууль”-ийг бүтээх, хөгжүүлэхэд чухал үүрэгтэй оролцогчдод хандан цөөн саналыг дэвшүүлээ.

Abstract

Due to the continual expansion and diversification of social relations, the need to regulate them increases day by day, leading to a constant growth in the volume of legal legislation. At the same time, citizens often lack sufficient legal knowledge to exercise and protect their rights and freedoms, to seek redress when these rights are violated, to access public services, and to participate independently and effectively in social relations.

In response to this issue, an approach known internationally as Visual Law has been developing. This approach communicates legal rules and procedures not through complex legal language, but by simplifying them through visual tools—such as diagrams, icons, and other illustrative methods.

This article aims to introduce the concept of Visual Law, which is

¹Шихихутуг их сургуулийн Судалгааны хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D)

relatively new in Mongolia, by outlining its main characteristics, significance, and key considerations for its application. Furthermore, the article provides several recommendations for stakeholders involved in the creation and development of Visual Law materials.

Энэ өгүүлэл CC BY-NC лицензийн дагуу нээлттэй хандалтын эрхтэй.



1. Танилцуулга

Энэхүү өгүүлэл нь “Visual Law” буюу хууль тогтоомжийг зураг, дүрс, схемээр хялбаршуулан илэрхийлэх арга зүйг танилцуулахад чиглэгдсэн. Өгүүлэлд Visual Law-ийн үндсэн онцлог, ач холбогдол, хэрэглээний боломжийг судлан, хууль тогтоомжийг иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй болгох ач холбогдлыг онцолсон.

Нийгмийн харилцаа өдрөөс өдөрт нарийн төвөгтэй болж, хууль тогтоомжийн хэмжээ тасралтгүй өсөхийн зэрэгцээ иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг хангалтгүй байгаа нь эрх зүйн боловсрол, төрийн үйлчилгээний хүртээмжид хүндрэл учруулж байна. Ийм нөхцөлд хууль тогтоомжийг зураг, схем, дүрслэлийн бусад хэрэгслээр хялбаршуулан дамжуулах нь иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах, төрийн үйлчилгээнд идэвхтэй оролцох боломжийг нэмэгдүүлдэг.

Өгүүлэлд Visual Law-ийг хэрэгжүүлэх үндсэн зарчим, хүн төвтэй хандлага, инфографик болон дизайн сэтгэлгээний ач холбогдол, хууль зүйн боловсролд үзүүлэх эерэг нөлөөг тайлбарласан. Мөн хууль тогтоомжийн хүртээмж, ил тод байдлыг нэмэгдүүлэх, дээд боловсролын сургалтын байгууллагуудад Visual Law-ийн хандлагыг нэвтрүүлэх, иргэдэд зориулсан дүрслэлийг хөгжүүлэх зөвлөмжийг дэвшүүлсэн.

2. Арга зүй

Энэ өгүүллийн арга зүй нь Visual Law буюу хууль тогтоомжийг дүрс, зураг, схем ашиглан хялбаршуулан дамжуулах шинэ хандлагыг танилцуулахад чиглэгдсэн бөгөөд голчлон олон улсын туршлага, онол, практик жишээн дээр тулгуурласан чанарын судалгаа юм. Судалгаанд хүний эрх төвтэй хандлага, дүрслэлээр мэдээлэл дамжуулах ач холбогдол, дизайн сэтгэлгээ, хууль зүйн дизайн зэрэг ойлголтыг хамруулан, хууль тогтоомжийн хүртээмж, иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх боломжийг онцолсон.

3. Судалгааны үр дүн

Нийгмийн хөгжлийн хурд, хувьсал, шинэ чиг хандлагыг даган өдрөөс өдөрт нийгмийн харилцаа шинэ агуулгаар баяжигдахын хирээр түүнийг зохицуулах хэрэгцээ шаардлага өсөж, улмаар эрх зүйн хэм хэмжээний цар хүрээ өргөжин тэлж байна. Нөгөө талаас эрх зүйт төрийн чухал нэг үүрэг нь нийгмийн харилцааг зохицуулахад хэрэгцээт хууль тогтоомжийг цаг ямагт баталж мөрдүүлэх, өөрчилж шинэчлэх явдал юм.

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системээс үзвэл өнөөдөр Монгол Улсад 900 гаруй хууль, тэдгээрийг дагаж гарсан хэдэн мянган нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон акт буюу дүрэм, журам үйлчилж байна.² Үүнээс нэг удаагийн шинжтэй харилцааг зохицуулсан хууль тогтоомжийг хасаад ч том тоо гарахаар байна. Жирийн иргэн байтугай хуульч хүн ч энэ хэмжээний хууль тогтоомжийг бүрэн ойлгож мэдэх, өдөр тутамдаа ашиглахад адармаатай байх нь аргагүй.

Иргэд хууль, эрх зүйн мэдлэг, мэдээлэл дутмаг байдал нь тэдний эрх, эрх чөлөө нь зөрчигдөхөд өртөх эмзэг байдлыг нэмэгдүүлдэг. Тэгвэл иргэдийг хууль, эрх зүйн наад захын мэдлэг, мэдээлэлтэй болгож, төрийн удирдлага, нийгэм, эдийн засаг, эрх зүйн харилцаанд идэвхтэй, бие даан оролцох, эрхээ хамгаалах боломжоор хангах нь дан ганц төрийн үүрэг бус, хууль зүйн сургалт, судалгааны бүхий л байгууллагын санаа тавих ёстой асуудал юм.

Судлаач Амелин бичсэн өгүүлэлдээ хууль тогтоомжийг иргэдэд ойлгомжтой байлгах талаарх төрийн үүргийг маш энгийнээр тайлбарлажээ.³ Эрх зүйд “*ignorantia juris non excusat*” буюу хууль мэдэхгүйгээс түүнийг зөрчих нь хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй зарчим үйлчилдэг. Ийм зөрчилд төрийн механизм ямар ч эмпати, өршөөлгүйгээр хариуцлага хүлээлгэхээр ажилладаг. Тэгвэл хууль тогтоогчид баталсан хууль тогтоомжоо иргэдэд хүргэж ойлгуулах талаар хир их хичээл зүтгэл гаргасан бэ гэх асуулт зүй ёсоор гарч ирнэ. Учир нь төрийн хүсэл сонирхол нь хууль мэдэхгүйгээс түүнийг зөрчсөн иргэдэд хариуцлага хүлээлгэхээс илүүтэй тэдний хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх замаар энэ мэт зөрчлөөс урьдчилан сэргийлэх байх учиртай.

Өөрөөр хэлбэл эрх зүйн хэм хэмжээг бүтээхдээ түүний нөлөөнд өртөх бүх талуудад ойлгомжтой байлгах буюу хүн төвтэй (*human-centric*) хандлагыг баримтлах нь чухал гэжээ. Хүн төвтэй хууль бүтээх хандлагыг баримталснаар иргэдийн хууль, эрх зүйн боловсрол дээшлэх, төр тогтоосон хэм хэмжээг дагаж мөрдүүлэх, зөрчсөнтэй хийх тэмцэлд зарцуулах хүчин чармайлт, нөөцөө хэмнэх боломжтой юм. Монгол Улсад Хууль тогтоомжийн тухай хуулиар хууль тогтоомжийн төсөл боловсруулах шатанд олон талын оролцоог хангахаар зохицуулсныг энд жишээ татаж болно.

Хууль тогтоомжийн ил тод, хүртээмжтэй байдлыг хангах, олон нийтэд сурталчлан таниулах, лавлагааны сангаар үйлчлэхэд “Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем” чухал үүрэгтэй билээ. Гэвч хууль тогтоомж хүртээмжтэй байх, ойлгомжтой байх нь тусдаа ойлголт юм. Хууль, эрх зүйн акт нь мэргэжлийн нэр томьёо, хэллэг ихээр агуулдгаас хэн бүхэнд шууд ойлгож ашиглах, тайлбарлахад амаргүй байдаг.

² www.legalinfo.mn, 2025.11.11

³ *Amelin Jabbur, (2020), A Brief Introduction to Visual Law, <https://www.legaltechnologist.co.uk/article/a-brief-introduction-to-visual-law/>, 2025.11.11*

Өнөө цагт Монгол Улсад иргэдэд хууль тогтоомжийг дүрслэн сурталчлах ажил цөөнгүй хийгдэж ирсэн нь голчлон сонгууль, авлигатай тэмцэх сэдвээр зурагт хуудас, богино хэмжээний видео, шторк хэлбэртэй байна. Мэдээж зарим төрийн байгууллагуудаас иргэдэд үзүүлж буй ажил, үйлчилгээгээ таниулах зорилгоор энэ мэт материал гаргаж байсан гэдэгт эргэлзэхгүй байна. Тэгвэл олон улсад хууль, эрх зүйн нарийн төвөгтэй зохицуулалт, үе шат, дэс дарааллыг иргэд, харилцагч, үйлчлүүлэгчид, цаашилбал хуулийн мэргэжлээр суралцаж буй оюутнуудад хялбаршуулан ойлгуулах зорилгоор хууль тогтоомжийг зураг, дүрс, схем гэх мэтээр илэрхийлэх чиг хандлагыг “Visual law”, “Law design” гэх зэргээр нэрлэн хөгжүүлж байна.

“Visual law” нэр томъёо нь монгол хэлэнд “Харааны хууль (эрх зүй)” гэж шууд орчуулагдахаар байна. Энэ нь нүдний хараа, хараа зүй зэрэг анагаах ухаанд холбогдох хэллэг, эсхүл түүнд холбогдох харилцааг зохицуулдаг хууль мэтээр андуурагдах магадлалтай юм. Иймд уг нэр томъёоны үндсэн утгыг илүү оновчтой илэрхийлэхүйц “Зурган хууль”, “Хардаг хууль”, “Дүрст хууль” зэрэг нэршлийг ашиглах боломжтой юм. Цаашид энд дурдсанаас илүү оновчтой нэршил гарч болохыг үгүйсгэхгүй бөгөөд тэр хүртэл [энэхүү өгүүлэлд] “Зурган хууль” гэх нэршлийг ашиглах болно.

Хүний тархи зурган мэдээллийг бичмэл мэдээллээс илүү хурдан боловсруулж ойлгодог, хурдан тогтоож, удаан мартдаг нь шинжлэх ухааны үндэслэлтэй баримт юм. Учир нь тархи бичмэл мэдээллийг дарааллаар, харин дүрсийг бүхэлд нь нэг дор хүлээж авдаг байна.⁴ Иймд хууль тогтоомжийг нуршсан, хэт мэргэжлийн хэллэг бүхий текст хэлбэрээр бус зураг, схем, дүрст байдлаар хүнд хүргэх нь илүү үр дүнтэй байх нь.

Хууль тогтоомжийг зураг гэх мэтээр хялбаршуулан илэрхийлэх нь дараах ач холбогдолтой. Үүнд:

Хууль, эрх зүйн талаарх иргэдийн ойлголт, хүртээмжийг дээшлүүлнэ. Жишээлбэл, иргэд эрхээ хамгаалах, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, төрийн үйлчилгээ авах, төрийн байгууллагад гомдол гаргах зэргээр эрх зүйн харилцаанд идэвхтэй, бие даан оролцох боломж нь нэмэгдэнэ.

Хууль зүйн үйлчилгээний чанар сайжирна. Хууль, шүүхийн болон төрийн бусад байгууллага, хууль зүйн болон өмгөөллийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд харилцагч, үйлчлүүлэгчдэдээ хууль зүйн нарийн төвөгтэй асуудал, шат дамжлагыг энгийн ойлгомжтойгоор хүргэж тайлбарлах, улмаар харилцан итгэлцэл-хяналтын түвшин, ил тод байдал дээшилнэ.

Хууль зүйн боловсрол шинэчлэгдэнэ. Хууль зүйн мэдлэгийг уламжлалт арга, хэлбэрээс гадна инфографик, урсгалын схем, дүрс, зургаар баяжуулан хүргэх, улмаар сургалтын чанар, үр дүнг ахиулах боломжтой.

⁴ Medina, J. (2014). *Brain rules: 12 principles for surviving and thriving at work, home, and school*. Pear Press.

Оюутны бүтээлч хандлагыг хөгжүүлнэ. Хуулийн их, дээд сургуульд суралцагчид дизайн сэтгэлгээ, загварчлал, бусад бүтээлч аргыг ашиглан мэдлэгийг боловсруулах, дамжуулах, хэрэглээнд нэвтрүүлэх чадварт суралцана.

2000 оны үед Канад Улсад хууль тогтоомжийн хэллэг, бичилт, дизайныг энгийнээр илэрхийлэх төслийн хүрээнд “Хөдөлмөр эрхлэлтийн даатгалын тухай хууль”-ийг хялбаршуулсан бөгөөд шинэ хувилбар нь бүх талуудын хүсэл сонирхолд нийцэн батлагдаад зогсохгүй, цаашид бусад хуулиудыг энэ мэтээр хялбаршуулахад жишиг болжээ. Ингэж хууль тогтоомжийг хялбаршуулах нь хууль тогтоомжийн хүртээмж, иргэдийн эрх зүйн мэдлэг, төрийн үйлчилгээний чанарыг нэмэгдүүлж, нөөцийг оновчтой зарцуулах боломж олгодог болохыг төслийг хэрэгжүүлэгчид онцолсон байна.⁵

Зурган хуулийн гол зорилгыг энгийнээр тодорхойлбол, мэргэжлийн нэр томьёо ихтэй, их хэмжээний текстэн мэдээллээс зайлсхийж, түүнийг илүү хялбараар илэрхийлэх явдал юм. Гэхдээ түүнийг зөвхөн зураг мэтээр явцуу ойлгож болохгүй. Учир нь зурган хууль нь сайтар бодож, боловсруулсан, логик, бүтээлч (creative), дизайн (design thinking) сэтгэлгээний үр дүн мөн. Нөгөө талаас зурган хууль нь нийтлэг хэм хэмжээ, зохицуулалт, тохиолдлыг голчлон илэрхийлэх бөгөөд тухайлсан нөхцөл байдлыг тусгадаггүй тул түүнийг хууль зүйн зөвлөгөө мэтээр ойлгох нь учир дутагдалтай.

Энэ дашрамд хоорондоо төсөөтэй дизайн сэтгэлгээ (design thinking), хууль зүйн дизайн (legal design) ба зурган хууль (visual law) зэрэг ойлголтуудын ялгааг товч тайлбарлая. Дизайн сэтгэлгээ нь аливаа асуудлын шийдлийг илүү бүтээлч, шинэлэг байдалд төвлөрч олох арга зүй бол хууль зүйн дизайн нь хууль зүйн бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчид хэрхэн хялбараар хүргэх тухай ойлголт юм. Ингэхдээ текстээс аль болох татгалзах, ойлгоход хэцүү үг, хэллэгээс зайлсхийх, хэрэгцээгүй агуулгыг хасах, форматын хэрэгслийг ашиглан мэдээллийн эрэмбийг харуулахад анхаарна. Тэгвэл зурган хууль нь хууль зүйн дизайны дэд салбар шинжтэй, дүрс, зургийн элементийг түлхүү ашиглах арга зүй, хандлага юм.

Зурган хуулийг хэрэгжүүлэхийн тулд хүн бүр график дизайнерын мэргэжилтэн байх албагүй бөгөөд энэ тал дээр мэргэжлийн хүнээс дэмжлэг авч болно. Гагцхүү дараах зарчмыг баримтлах учиртай.

- Тухайн мэдээллийн хэрэглэгч, тэдгээрийн хэрэгцээ, шаардлагыг зөв таньж тодорхойлох.
- Өгөх гэж буй мэдээллийн хэмжээг оновчтой тооцож, зорилгодоо таарсан хэмжээгээр мэдээллийг хүргэх.
- Гагцхүү үнэн бодит мэдээлэл түгээх.
- Мэдээллийн агуулга нь зорилгодоо нийцсэн байх.
- Өнгө, дүрс, хэмжээ зэргийг ашиглан онцлох санаагаа тодотгох.

⁵ David Berman, (2000), *Toward a New Format for Canadian Legislation: Using graphic design principles and methods to improve public access to the law*, <https://davidberman.com/wp-content/uploads/NewFormatForCanadianLegislation.pdf>

- Аль болох энгийн, ойлгомжтой, анхаарал татаж, хурдан тогтоогдох хэлбэртэй байх.

Зурган хуулийг ашиглан, мэдээллийг хэрхэн хялбаршуулж болох тухай ганцхан жишээг⁶ дор харуулав. Эхний зурагт (1) гэрээ дуусгавар болсны дараах зарим үүргийг зохицуулсан гэрээний бичмэл зүйл, заалт харагдаж байгаа бол дараагийн зурагт (2) тухайн зохицуулалтыг цаг хугацааны урсгалын схемээр харуулсан нь илүү энгийн, ойлгомжтой харагдаж байна.

Зураг 1

Terms relevant to termination in a Subcontracting Agreement

4. Competition and intellectual property rights

4.1. Supplier shall not compete with Customer or assist others to compete against Customer. In particular Supplier shall not develop or sell services, which are identical with, or similar to, the Customer Service if not otherwise separately agreed. [The commitment not to compete shall also be valid for a period of 6 months after the termination of this Agreement.] [The commitment not to compete shall also be valid for a period of 12 months after the termination of this Agreement.]

4.2. All programs, specifications, documentation and all other technical information prepared by Supplier in connection with the performance of his services hereunder will become the Customer's sole property. Title to all material and documentation furnished by the Customer to Supplier or delivered by Customer into Supplier's possession shall remain with the Customer. Supplier shall immediately return all such material or documentation within seven (7) days of any request or upon the termination or conclusion of his engagement under this Agreement, whichever shall occur first.

4.3. Customer shall have the right to use the whole work, any part or parts thereof, or none of the work, as it sees fit. Customer may alter the work, add to it, or combine it with any other work or works, at its sole discretion. Nevertheless, of the work or as part of the printings, printouts, documentation the Customer whether or not the

4.4. Supplier warrants that the work does not infringe any rights of third parties

4.5. Customer's trademarks, trade names recognized by Supplier as Customer's such property rights of Customer

6. Confidentiality

6.1. [Supplier shall not during the term of this agreement or 3 years thereafter disclose to any third party without prior written consent of Customer any confidential information relating to the Customer's Service, technology, intellectual property rights, customers, processes, financial information, affairs, business or method of carrying on business. Supplier further agrees to use such information only for the purpose of fulfilling this Agreement.] [Supplier shall not during the term of this agreement or 5 years thereafter disclose to any third party without prior written consent of Customer any confidential information relating to the Customer's Service, technology, intellectual property rights, customers, processes, financial information, affairs, business or method of carrying on business.]

7. Term of Agreement

7.1. This Agreement enters into force upon signing by both Parties and shall remain in force for an indefinite period of time unless terminated by either by giving the other party written notice at least fourteen (14) days. In case of a substantial breach of contract, this Agreement may be terminated with an immediate effect by either party giving the other party a written notice.

© Lawyers Design School

⁶ Hannale Korhonen, *Visual Law: Definition, Uses, and Benefits*, <https://lawyersdesignschool.com/visual-law-for-lawyers-the-end-of-dense-legal-writing/>, 2025.11.11



Хууль тогтоомжийг зургаар илэрхийлэх нь тухайн этгээдээс *visual thinking* буюу зурган, эсхүл дүрст сэтгэлгээг хөгжүүлэхийг шаарддаг. Тухайлбал,

- Бичгийн фонт, хэмжээ, өнгө, өргөн, налуу, тодруулалт гэх зэргийг ашиглан өгч буй мэдээллийн ач холбогдол, эрэмбэ, агуулгыг тодотгох.
- Цэс, дугаарлалт, параграф, хоосон зай, байршил гэх зэргийг ашиглан мэдээллээ эмх цэгцтэй хүргэх.
- Цаг хугацаа, үйл явцын урсгалын схем, хүснэгт, диаграмм, сум, зураас гэх зэрэг инфографикийн хэрэгслийг оновчтой ашиглах.
- Жижиг дүрс, зураг, лого, таних тэмдэг гэх зэргийг ашиглан уншигчийн анхаарлыг татах гэх мэт.⁷

4. Дүгнэлт

Эцэст нь дүгнэхэд бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх, дээд боловсролын чанарыг сайжруулах, хууль зүйн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг нь үндэсний болон олон улсын хөгжлийн баримт бичгүүдэд туссан чухал зорилт билээ. Энэ зорилтын хүрээнд иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэхэд дан ганц төрийн байгууллага бус дээд боловсролын сургалтын байгууллагуудын идэвх, оролцоо чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын хувьд хууль тогтоомжийг иргэдэд сурталчлан таниулах, төрийн үйлчилгээний шат дамжлага, зохицуулалтыг иргэдэд дүрслэн харуулах санаачилгууд байсаар ирсэн ч “Зурган хууль” гэх нэршлээр олон улсын чиг хандлага болж буй агуулга, зарчмаар хөгжсөн гэж үзэхээргүй байна.

Хууль тогтоомжийг зураглан илэрхийлэхийн ач холбогдлыг энд давтан өгүүлэх шаардлагагүй. Харин түүний үр шимийг хүртэгч нь дан ганц иргэд бус төрийн үйлчилгээг

⁷ Margaret Hagan, *Illustrated law & legal visualizations*. <https://www.openlawlab.com/project-topics/illustrated-law-visualizations/?utm>

авч буй хэн бүхэн, хууль, шүүхийн байгууллага, хууль зүйн үйлчилгээ үзүүлэгч этгээд, хууль зүйн сургалт, судалгааны байгууллага, багш, суралцагчид төдийгүй төрийн байгууллага, төр өөрөө болохыг онцолмоор байна.

Өгүүллийнхээ төгсгөлд “Зурган хууль”-ийн хандлага, сэтгэлгээг хөгжүүлж, практикт түгээмэл нэвтрүүлэхэд манлайлан оролцох учиртай түүнийг “бүтээгч” талуудад хандан дараах саналыг гаргаж байна.

- Хууль, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний акт гаргахын өмнө төдийгүй тэдгээрийг батлагдаж гарсны дараа ч хүн төвтэй хандлагыг удирдлага болгож, боломжит тохиол бүрд эрх зүйн актыг энгийн, ойлгомжтойгоор нийтэд түгээх,

- Төрийн үйлчилгээг үзүүлж буй аливаа этгээд ил тод байдал, хяналт-итгэлцлийг хангах, үйлчилгээний шуурхай байдал, чанарыг сайжруулах зорилгоор үйлчилгээний шат дамжлага, хугацаа бусад гол мэдээллийг хялбаршуулсан хэлбэрээр байнга нийтэд хүргэх соёлыг нэвтрүүлэх,

- Хууль зүйн дээд боловсрол олгож буй их, дээд сургуулиуд сурталтандаа “Зурган хууль”-ийн хандлага, сэтгэлгээг нэвтрүүлэх, багш-суралцагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, төгсөгчдөдөө энэ төрлийн ур чадварыг эзэмшүүлэх,

- Төрийн үйлчилгээ авах, эрхээ эдлэх, хамгаалах, сэргээлгэх нийгмийн харилцаанд оролцоход иргэдэд нэн шаардлагатай хууль тогтоомжийн зохицуулалт, процессыг хялбаршуулан зураглах чиглэлээр бичил төсөл санаачлах, түүнийг санхүүжүүлэх.

5. Эх сурвалж

- *Hannale Korhonen*, Visual Law: Definition, Uses, and Benefits.
<https://lawyersdesignschool.com/visual-law-for-lawyers-the-end-of-dense-legal-writing/>
- *Margaret Hagan*, Illustrated law & legal visualizations.
https://www.openlawlab.com/project-topics/illustrated-law-visualizations/?utm_source=chatgpt.com
- *Margaret Hagan*, A Beginner's List of Links for those interested in visuals + law,
<https://www.openlawlab.com/2019/02/15/a-beginners-list-of-links-for-those-interested-in-visuals-law/>
- *Medina, J.* (2014). *Brain rules: 12 principles for surviving and thriving at work, home, and school.* Pear Press.
- *David Berman*, (2000), *Toward a New Format for Canadian Legislation: Using graphic design principles and methods to improve public access to the law.*
<https://davidberman.com/wp-content/uploads/NewFormatForCanadianLegislation.pdf>